

Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн
118 дугаар тогтоолын 08 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

..... дүүргийн
Нийгмийн даатгалын хэлтэс

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хяналт шалгалтын байцаагч

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот,
дүүрэг, дүгээр хороо,
.....

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, хяналт, шалгалт хийх, нийгмийн даатгалын сангийн төсөв, түүний гүйцэтгэлд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах.
- 2.Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын хэрэгжилт, хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх, нийгмийн даатгалын сангийн төсөв, түүний гүйцэтгэлд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах.
- 3.Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш |
|---------------------------|--|---|--|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудад чиг үүргийн дагуу санал өгөх, хэрэгжүүлэх; | Үйл ажиллагааны хөтөлбөр болон төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна. | Г |
| | 2.Тухайн жилд дэвшүүлсэн зорилтын хүрээнд чиг үүргийн дагуу санал өгөх, хэрэгжүүлэх; | Санал нь холбогдох хууль тогтоомжтой уялдаж, хэрэгжсэн байна. | Г |
| | 3.Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд чиг үүргийн дагуу санал өгөх, хэрэгжүүлэх. | Хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж, хэрэгжүүлсэн байна. | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Байгууллагын дотоод үйл ажиллагаа болон ажил олгогч байгууллагад Нийгмийн даатгалын тухай багц хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалт, үнэлгээ хийх; | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажилласан байна. | Г |
| | 2.Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах; | Хяналт шалгалтаар илэрсэн төлбөрийг бүрэн барагдуулж, зөрчлийг арилгуулсан байна. | Г |
| | 3.Хяналт шалгалтын дүнг нэгтгэн цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулж хэлэлцүүлэх, тодорхой арга хэмжээний саналыг холбогдох газарт | Саналыг холбогдох газарт хүргүүлж, тодорхой үр дүнд хүрсэн байна. | Г |



| | | |
|---|--|------|
| хүргүүлэх; | | |
| 4.Эрх бүхий байгууллагын улсын байцаагчийн актаар тогтоосон шимтгэлийн өр авлагыг барагдуулах, хяналт тавих; | Актын барагдуулалтийг ханган ажилласан байна. | Г, Х |
| 5.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх; | Холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна. | Г |
| 6. Актаар тогтоосон шимтгэлийн өр авлагыг барагдуулах ажлын хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйгээр хангах; | Актаар тогтоосон шимтгэлийн өр авлагыг барагдуулсан байна. | Г, Х |
| 7.Ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, ногдуулалтыг мэдээллийн сангийн бүрдүүлэлттэй тулган шалгаж, хяналт тавих ажлыг зохион байгуулах; | Дотоод үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна. | Г, Х |
| 8.Нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг зохион байгуулж, үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах; | Сангийн үйл ажиллагааны гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгч ажилласан байна. | Г, Х |
| 9.Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган, хяналт тавих; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Г, Х |
| 10.Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын их хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэл, дүүргийн засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэл, дүүргийн засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл болон дээд газраас цаг үеийн асуудлаар гаргасан | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журмын хэрэгжилтэд нийцсэн байна. | Г, Х |



| | | | |
|---------------------------|---|---|------|
| | үүрэг даалгаварын биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, тайлагнах; | | |
| | 11.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, засгийн газрын тогтоолын биелэлтэнд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, хэлтсийн даргад танилцуулах, тайлагнах; | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Г, Х |
| | 12.Төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр ашигтай хуваарилалтад дотоод аудит хийх, дүгнэлт гаргах, дүгнэлтийн дагуу хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, хэлтсийн даргад танилцуулах, тайлагнах; | Дотоод аудит хийгдэж, үр дүнг тооцож ажилласан байна. | Г, Х |
| | 13.Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын систем” –д тулгуурлан дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, үр дүнг тооцох. | Үр дүнг тооцож ажилласан байна. | Г,Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Үйл ажиллагааны болон Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, ажлын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлүүлэх, тайлагнах; | Хууль тогтоомжид заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн байна. | Г |
| | 2.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллах; | Холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласан байна. | Г |
| | 3.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтийг хангах, тайлагнах; | Үүрэг даалгавар цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна. | Г |
| | 4.Өргөдөл, гомдол, санал, албан бичигт хариу өгөх; | Хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлэсэн байна. | Г |
| | 5.Ажлын чиг үүрэгтэй холбоотой судалгаа, мэдээ, тайлан гаргах | Тухай бүр гаргасан байна. | Г |



| | | | |
|--|--|---|---|
| | 6.Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллах; | Заавар, стандартыг мөрдөж ажилласан байна. | Г |
| | 7. Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөх; | Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байна. | Г |
| | 8.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах | Ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Г |
| | 9.Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх; | Мэдээллийн нууц алдагдаагүй байна. | Г |
| | 10.Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах; | Зохион байгуулагдсан ажилд идэвхтэй оролцсон байна. | Г |
| | 11.Ажлын цагийг баримтлах, цаг ашиглалтыг сайжруулах; | Ажлын цаг ашиглалт сайжирсан байна. | Г |
| | 12.Ажлын байранд дүрэмт хувцсыг журамд заасны дагуу өмсөж ажиллах; | Дүрэмт хувцсыг өмсөж хэвшсэн байна. | Г |
| | 13.Цаг үеийн шинж чанартай бусад үйл ажиллагаанд оролцох, хэрэгжилтийг ханган ажиллах. | Тухай бүр оролцсон байна. | Г |

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|-----------|--|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | -нягтлан бодох бүртгэл /0.4110.1/; -санхүү /0.4120.1/; -даатгал /0.4120.2/; -эдийн засаг /0.311.01/; -эрх зүй /042/. |
| Мэргэшил | Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. |
| Туршлага | Нийгмийн даатгалын салбарт туслах эсхүл дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх. |



| | | |
|-----------|--------------------|--|
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | <ul style="list-style-type: none"> - нийгмийн даатгалын салбарын чиглэлээр мэдээлэл цуглуулах, мэдээлэл дэхь дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - бодлогын судалгааны чанарын болон тоон аргыг ашиглан дүн шинжилгээ хийх; - нийгмийн даатгалын салбарын чиглэлээр хариуцан гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - нийгмийн даатгалын салбарын асуудлын хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - нийгмийн даатгалын салбарын асуудлаар судалгаа хийж дүнг хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад. |
| | Багаар ажиллах | <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зарчимч, тууштай байх, - ажлын цаг ашиглалтын хувьд нэгжийн хамт олныг үлгэрлэх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - бусад; |
| | Бусад | <ul style="list-style-type: none"> - нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхтэй байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр хагаж ажиллах чадвартай байх; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх. |

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга, харьяалах тасгийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- 1.Төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах;
- 2.Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай харилцах;
- 3.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн



байгууллага.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан.

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:

НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

О.БАЙГАЛМАА

Шийдвэрийн огноо: 20 04 01

20... оны ... сарын ... -ны өдөр

Дугаар: 110

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

..... ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Шийдвэрийн огноо:

Дугаар:

(тамга/тэмдэг)

ДАРГА

(Гарын үсэг)

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

